

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2021 – 11 сар | Дугаар 36

## ГАРЧИГ


- 1–3 Бодлогын нийтлэл
- 4–6 Зохицуулалтын мэдээ
- 7–9 Байр суурь
- 10 ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ
- 11–13 НОГООН ДААТГАЛ
- 14 ФИНТЕК БА РЕГТЕК
- 15–19 Судлаачийн индэр
- 20–21 Цуврал хичээл
- 22–23 Компанийн засаглал
- 24–25 Олон улсын зах зээлийн мэдээ
- 26 Олон улсын хөрөнгийн зээлийн индекс

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дотоодын аж ахуйн нэгжүүдийн орлого буурч, эдийн засгийн өсөлт өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд тохиолдоогүйгээр анх удаа сөрөг гарч, экспортын орлого хумигдаж, төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээ өсөх зэргээр макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах хүндхэн үетэй тулгарч байсан. 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, салбарын хөгжлийг удаашруулахгүйгээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагааг төрийн зохицуулалтын бодлогоор дэмжиж, хувийн хэвшилтэй нягт хамтран ажилласны үр дүнд 2021 оны 11 дүгээр сарын байдлаар зах зээлийн үнэлгээ Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсэн бий болсон 30 жилийн хугацаанд түүхэн дээд түвшинд буюу 5.2 их наяд төгрөгт хүрч, олон улсын санхүүгийн зах зээлд хамгийн өндөр өсөлт, гүйцэтгэлийг үзүүлсэн хөрөнгийн зах зээлтэй улс болсон.

Ковид-19 цар тахал Монгол Улсад гарч, нэмэгдэх хандлагатай байх үед Засгийн газрын зүгээс дотоодод хөл хориог хэсэгчилсэн байдлаар тогтоосон. 2020 оны 2 дугаар сарын байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2.76 их наяд төгрөг байсан бол 2021 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлийн үнэлгээ 4.97 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91.1 хувиар өсөж, компанийн хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг, зах

зээлийн үнэлгээгээр өндөр нэр бүхий 20 бүртгэлтэй компаниас бүрддэг Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс 42,937.26 нэгжид хүрч, өмнөх оны мөн үеэс 25,405.62 нэгж буюу 144.9 хувиар өссөн. Олон улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг Блүүмбэрг компаниас тооцон гаргадаг анхдагч хувьцааны индекс /primary equity index/-д багтсан орнуудаас хамгийн өндөр өсөлттэй нь Монгол Улс болсныг онцолсон. Тухайлбал, дотоодын хөрөнгийн зах зээлд гарсан энэхүү өндөр өсөлт, амжилт нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, сонирхол нэмэгдэх, хувийн хэвшлээс шинэ бүтээгдэхүүн гаргах замаар урт хугацааны санхүүжилтийг татах нь ихсэж байгааг харуулахаас гадна цаашид хөрөнгийн зах зээл нь өндөр өсөлтөө хадгалж, тогтвортойгоор өснө гэсэн эерэг хүлээлтийг хөрөнгө оруулагчдын дунд үүсгэж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө дотоодод гарч эхэлсэн үеэс хойших хугацаанд хөрөнгийн зах зээлд гарч буй дээрх өндөр өсөлт, амжилтыг хэвээр хадгалах, иргэдийн хөрөнгийн зах зээлээс хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, аж ахуй нэгж, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын идэвх, сонирхлыг



нэмэгдүүлэх, олон нийтэд санал болгон хувьцаа, компанийн бонд гаргахтай холбоотой зардал, өртөг, хугацааг бууруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог

нэмэгдүүлэх, олон улсын зохицуулалтыг нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлээ.


Үргэлжлэл 2-р нүүрт >>



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ЗАЛИЛАН

Материаллаг давуу тал бий болгохын тулд бичиг баримт болон үйл ажиллагаагаар хуурамч нотолгоо гаргах



### FRAUD

A false representation by means of a statement or conduct, in order to gain a material advantage.

*Эх сурвалж:*

*Банк санхүүгийн тайлбар толь бичиг*


## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

*Эхлэл 1-р нүүрт >>*

**Банкны салбарын реформ:** Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг тус тус баталсан. Дээрх хууль тогтоомжийн хүрээнд банкны системд нөлөө бүхий банкнууд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулах замаар нээлттэй хувьцаат компани болох, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор банкны хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байхаар төвлөрлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн. Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 дугаар хамтарсан тушаалаар “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төвлөлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”-ыг баталсан бөгөөд уг түр журмаар банкнууд төвлөлөгөөндөө хувьцаагаа олон нийтэд санал болгох ажиллагаа, хэрэгжүүлэх хугацаа, үнэ тогтоох аргачлал, санал болгох хувь, хөрөнгө оруулагчдын бүтэц зэрэг мэдээллийг тусгасан байхаар зохицуулсан. 2021 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо нийт 11 банкнаас 10 банкны төвлөлөгөөг бүрэн хянаж, холбогдох мэдээллийг Монголбанканд хүргүүлж ажилласан. Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд банкны системд нөлөө бүхий банкнууд олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани болсноор төрийн хоёр зохицуулагч байгууллага болох Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад давхар орох бөгөөд СЗХ-ны зүгээс банкнууд үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргах, гаргасан үнэт цаасыг бүртгэх, хувьцаат компани хэлбэртэй банкны компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал, санхүүгийн тайлагнал, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээх үүргийг хангуулах хүрээнд хяналт тавьж ажиллана.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 дугаар хамтарсан тушаалаар “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг баталсан бөгөөд энэ журмын хүрээнд банкнуудын нийт хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авсан этгээд, нээлттэй хувьцаат компани болох банк Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авах, банкны хувьцаа худалдан авах этгээд өөрийн болон холбогдох этгээдийн талаарх мэдээллийг бүрдүүлж өгөх зэрэг харилцааг зохицуулах онцлогтой. Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 508 дугаар тогтоолоор “Богд банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгэсэн бөгөөд ингэснээр Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд хамгийн анх удаа нийтэд санал болгон хувьцаагаа гаргаж буй банк болж байгаа юм. Олон улсын валютын сан (2016)-аас санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс /financial development/-ийг тооцон гаргасан бөгөөд уг хөгжлийн индекс нь санхүүгийн байгууллагын индекс /financial institutions/ болон санхүүгийн хөгжлийн индекс /financial development index/ гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрддэг. 2019 оны байдлаар, Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийг дээрх индексээр тооцоолоход санхүүгийн байгууллагын индекс 0.63, санхүүгийн хөгжлийн индекс 0.15-тай байгаа нь санхүүгийн салбарт банкны салбарын гүйцэтгэх үүрэг өндөр байгааг харуулахаас гадна зохистой харьцааны шалгуурын хүрээнд банкнуудын зүгээс хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах, компанийн бонд гаргах зэргээр тоглогч болох бололцоо банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор нэмэгдэх юм. Түүнчлэн, Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ урьдчилсан тооцоогоор 5.6 их наяд төгрөгөөр огцом өсөж, чанартай, хөрвөх чадвар өндөртэй шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь сайжрах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, сонирхол нэмэгдэхээс гадна арилжааны банкнуудын компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжрах, хувьцаа



зээмшлийн төвлөрөл буурч, иргэд, олон нийтийн өмчлөлд шилжих, цаашид олон тулгуурт санхүүгийн зах зээлийн тогтолцоо бий болох эхний алхам бүрдэх чухал ач холбогдолтой.

**Биржийн бус зах зээлийн эрх зүйн орчны шинэчлэл:** Санхүүгийн зохицуулах хорооноос “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталснаар Монгол Улсад анх удаа үнэт цаас гаргагч компаниудаас арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэлийн өндөр шалгуурыг хангахгүйгээр биржийн бус зах зээлд түргэвчилсэн, шуурхай байдлаар компанийн өрийн хэрэгслийг гаргаж, урт хугацааны санхүүжилт татах зохицуулалтын орчин бүрдсэн. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо /МУЦАЭХ/-ноос биржийн бус арилжааны платформийг нэвтрүүлснээр хувийн хэвшлээс банкны зээлийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц бүтээгдэхүүн болох компанийн бондыг 2021 оны 9 дүгээр сараас амжилттай гаргаж эхэлсэн ба 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 11 аж ахуйн нэгжээс нийт 189 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа биржийн бус зах зээл дээр идэвхтэй явагдаж байна. Мөн Инновацийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т “Гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэж заасантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 8 дугаар сарын хуралдаанаар “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д шинээр тусгасан гарааны компани биржийн бус зах зээлд олон нийтэд хувьцаагаа санал болгох зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Ингэснээр гарааны компаниуд биржийн бус зах зээлээр дамжуулан төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтаа үе шаттайгаар мэргэжлийн хөрөнгө оруулагчид, өндөр орлоготой эрсдэл даах чадвартай иргэдээс татан төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалтын орчныг анх удаа амжилттай бүрдүүлсэн.

**Үнэт цаасны салбарын зохицуулалтын шинэчлэл:** Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтын орчныг сайжруулах, олон улсын чиг хандлагад нийцүүлэх хүрээнд Сангийн сайдын 2021 оны 52 дугаар тушаалаар байгуулсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс салбарын гол хуулиуд болох Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Компанийн тухай хуульд нэн шаардлагатай байгаа нэмэлт өөрчлөлтүүдийг тусган эцэслэн боловсруулсан ба улмаар дээрх хуулийн төслүүдийг 2021 оны Улсын Их Хурлын намрын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг тус тус өөрийн орны онцлог, зах зээлийн нөхцөл байдал болон олон улсын жишигт нийцүүлэн баталсан. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын хувьд нийтэд санал болгох ажиллагааг андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулах, уг ажиллагааг хялбар, шуурхай болгох, андеррайтерийн чиг үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх хүрээнд хувьцааны үнийг тогтворжуулах, нийтэд санал болгох үнэт цаасны үнийг тогтоох зохицуулалтыг шинээр оруулж, үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулснаас гадна үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэх хууль, аудит, хөрөнгийн үнэлгээний компаниудад тавигдах шалгуурыг нэмэгдүүлсэн. 2021 оны 3 дугаар улирлын байдлаар “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК нь нийтэд санал болгон анх удаа хувьцаа /IPO/ гаргаж, нийт 28.7 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд энэ нь 2019 оноос хойших хугацаанд дотоодын аж ахуйн нэгж нээлттэй хувьцаат компани болсон анхны тохиолдол болж байна. “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын хувьд компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй холбоотойгоор компанийн бонд гаргахад Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хийгддэг хяналтын ажиллагааны давхардлыг арилгах, бүртгэлийн үйл ажиллагааны хугацааг багасгах, нэг удаа Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн өрийн хэрэгслийг хэсэгчлэн, үе

шаттайгаар нийтэд санал болгох /shelf-registration/ болон Монгол Улсад анх удаа “Ногоон бонд”-ыг аж ахуй нэгжүүд гаргах эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлсэн. 2021 он гарснаар дотоодын 4 аж ахуй нэгжээс компанийн бонд гаргах замаар нийт 576.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн ба “Мобифинанс ББСБ” ХХК-аас нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг дээрх шинэ журмын дагуу бүртгэж, анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагааг андеррайтерийн компани гар утасны аппликейшнээр дамжуулан хэрэгжүүлснээр анхны “Дижитал бонд” зах зээлд бий болсон.

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжил: Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас гаргасан бодлогын зөвлөмж, суурь зарчмын хүрээнд Т+2 горимд бүрэн шилжүүлж, төлбөрийн эсрэг нийлүүлэлт /DvP/ зарчмыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн. Ингэснээр үнэт цаасны зах зээлийн төлбөр тооцоо олон улсын жишигт нийцэж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо өсөх суурь нөхцөл бүрдсэн ба улмаар хөрөнгийн зах зээлийн индексийг тооцдог Их Британийн FTSE Russell группээс 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг “Хөгжиж буй” /Frontier Market/ зах зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын жагсаалт”-нд /Watch List/ эргүүлэн багтаасан нь томоохон амжилтуудын нэг болсон. Мөн үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн тогтолцоог шинэчлэх хүрээнд мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны тогтолцоог бүрдүүлж, харилцагчдад үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай болгох чиглэлээр мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны зохицуулалтыг бүрдүүлсэн.

**Хөрөнгийн зах зээл дэх шинэ бүтээгдэхүүн, мэргэжлийн хөрөнгө оруулагчид:** Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд зөвхөн хувьцаа, бонд гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүн л арилжаалагддаг байсан бол Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарал хандуулж, бодлого, зохицуулалтаар дэмжсэний үр дүнд 2020–2021 онд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалагддаг хамтын сан /ХОС/, компанийн бонд, анхны арилжааны зориулалттай буюу хөтөлбөрийн бус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /ХБҮЦ/ зэрэг нийт 27 төрлийн бүтээгдэхүүн гарсан байгаа нь хөрөнгийн зах зээлд чанартай, хөрвөх чадвар өндөр бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах эрэлт, хэрэгцээ өндөр байгааг харуулж байна. Ялангуяа, 2021 он гарснаар хөрөнгийн зах зээл идэвхжиж, иргэд, хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл нэмэгдэхийн зэрэгцээ өндөр өгөөж бүхий санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж байгаа нь эрэлт талаас Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд банкнууд олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар нээлттэй хувьцаат компани болоход урьдач нөхцөл бүрдэх боломжтойг харуулж байна. Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдсэнээр мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо, сонирхол өсөх, үйл ажиллагаа нь идэвхжих, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын урсгал дотоодын зах зээлд орох давуу талтай байдаг тул Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд сонгодог утгаар институциональ хөрөнгө оруулагчид болох “Хамтын сан” эхнээсээ бий болж байгаа нь цаашид хөрөнгө зах зээл тогтвортой хөгжихөд чухал ач холбогдолтой юм /анхны хамтын сан 2020 онд бий болсон/.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### “СОРЬЦ 2021” АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО



Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газар, Голомт банк, Үнэт металлын үндэсний холбоо хамтран зохион байгуулсан “Сорьц 2021” харилцагчидтай уулзах уулзалт боллоо. Уулзалтад Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг төрийн



байгууллага болон Сорьцын хяналтын газрын харилцагч байгууллага, иргэд оролцсон юм. Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Н.Энхтуяа салбарын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл өгсөн бол Сорьцын хяналтын газраас өнөөгийн нөхцөл байдлын талаар тайлбарлаж, төр, хувийн хэвшил хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцов. Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 11 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 436 иргэн, 39 хуулийн этгээдэд олгоод байна.

### “МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ФОРУМ-2021”



### БОЛЛОО

“Эерэг өөрчлөлтийг санхүүжүүлэе” сэдвийн хүрээнд “Монголын тогтвортой санхүүгийн форум-2021” 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулагдлаа. Парисын хэлэлцээрээр хүлээсэн Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх, эрүүл аюулгүй, хүн байгальдаа ээлтэй ирээдүйг цогцлооход төр, хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэн бэхжүүлэх зорилгоор зохион байгуулж буй форумыг нээж Санхүүгийн зохицуулах хорооны



дарга Д.Баярсайхан хэлсэн үгэндээ Монгол Улсад “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийг 2013 онд хэрэгжүүлж эхэлснээс хойш Санхүүгийн зохицуулах хорооноос хөтөлбөрийг дэмжиж урт хугацааны тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, ногоон хөрөнгийн зах зээлийг бий болгох, олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд ашиглаж буй ногоон фонд гаргах зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлээр

Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоо, Олон улсын санхүүгийн корпораци, Олон улсын санхүүгийн хүртээмжийн холбоо, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажилласаар ирсэн. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Ногоон таксономи”-г анх удаа баталснаар дэлхийн хэмжээнд таксономиг анхлан баталсан цөөн орнуудын нэг нь Монгол Улс болсон юм.

Сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулах, эрчим



хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, хог хаягдлын асуудлыг үр ашигтайгаар шийдвэрлэх, дэвшилтэт технологийг ашиглах замаар ногоон санхүүжилтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдээс ч “ногоон бонд” гаргах явдал ихэссэн. Үүнтэй холбогдуулж Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн бондын бүртгэлийн зохицуулалтад өөрчлөлт оруулж дотоодын аж ахуй нэгжүүдээс шинэ бүтээгдэхүүн болох “ногоон бонд”-ыг гаргах зохицуулалтыг шинээр тусгасан. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлд анх удаа олон улсын жишигт нийцсэн “ногоон бонд” гарах боломжтой болсныг Та бүхэнд дуулахад таатай байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох байгууллагуудтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчин, нийгэм, засаглал /БОНЗ/-ын стандарт, тайлагналыг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэ стандарт нэвтэрснээр нээлттэй хувьцаат компанийн байгаль орчин, нийгэм, засаглалын талаарх мэдээлэл олон нийт, хөрөнгө оруулагчдад илүү нээлттэй, ил тод болно. Хувьцаат компаниудад ч гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх, шинэ зах зээлд гарахын зэрэгцээ байгаль, хүрээлэн буй орчинд эерэг нөлөө авчрах зэрэг давуу талуудтай. Санхүүгийн зохицуулах хороо цаашид ч тогтвортой, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхийг тууштай дэмжиж ажиллах болно” гэдгийг онцолсон юм. Форумын үеэр Монгол Улсын санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээлийг тогтвортой, ногоон хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хөгжүүлэх, тогтвортой санхүүжилтийг дэмжих чиглэлд хамтран ажиллах, олон улсын стандартыг нэвтрүүлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой бизнесийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоо харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичгийн хүрээнд хоёр тал хөрөнгийн

зах зээлд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах, дасан зохицох, “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”-ын хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийг төр, хувийн хэвшлийн түншлэлд үндэслэн боловсруулах, “Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зорилт”-уудын санхүүжилтийн таксономийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон холбогдох талуудын саналыг тусган хамтран боловсруулах зэрэг хэд хэдэн ажлыг хийж хэрэгжүүлэх юм.

## МОНГОЛЫН АНХНЫ ДИЖИТАЛ БОНДЫН ЦАНГ ЦОХИЛОО



СЗХ-ноос зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудтай хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын томоохон арга хэмжээнүүдийг үе шаттайгаар, цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж байна. Үүний нэг болох “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг баталж, өнгөрсөн 9 дүгээр сараас мөрдөж эхэлсэн. Энэхүү зохицуулалтын хүрээнд хамгийн анхны нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг “Мобифинанс ББСБ” ХХК-аас гаргасны дагуу СЗХ бүртгэсэн. 11 дүгээр сарын 16-ны өдөр тус компанийн олон нийтэд нээлттэйгээр санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн арилжааны цан цохин ёслол боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай, Мобиком группийн санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал Б.Үнэнбат, “Өлзий энд Ко капитал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр болон холбогдох бусад хүмүүс оролцсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан цан цохих ёслолыг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, банкны зээлтэй өрсөлдөхүйц санхүүжилтийн

тогтолцоог бий болгох, олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг баталсан. Уг журмаар компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлтэй адилтган авч үзэж байсныг засаж, тодорхой шаардлага хангасан бонд гаргагчийн нийтэд санал болгон гаргах бондыг хялбаршуулсан горимоор богино хугацаанд бүртгэх, өрийн хэрэгслийг үе шаттайгаар гаргах, дотоодын аж ахуйн нэгжүүд “Ногоон бонд” гаргах, аж ахуй нэгжүүд цаг хугацаа, зардал хэмнэж, богино хугацаанд санхүүжилт татах боломжуудыг бүрдүүлсэн.

“Мобифинанс ББСБ” ХХК нь энэхүү журмын хүрээнд өрийн хэрэгслээ бүртгүүлсэн анхны компани бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компани зохион байгуулснаараа онцлогтой. Өнгөрсөн 3 дугаар сард “Сэндбоксыг зохицуулалтын орчны журам”-ыг баталснаар бий болсон сэндбоксын зохицуулалтын орчин дахь анхны бүтээгдэхүүн болж, өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар нэг тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааг Монпэй аппликейшн /Monpay/ ашиглан шинэлэг байдлаар зохион байгуулсан нь 2017 онд Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаас хойш цахим мөнгөөр үнэт цаас худалдан авч буй анхны тохиолдол” гэдгийг онцоллоо.

### ИРГЭД, ДААТГУУЛАГЧДАД ХҮРГЭХ ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 онд шинэчлэн баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн хүрээнд даатгалын бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааг илүү хялбаршуулаад байна. Тус журмаар даатгалын компани нь бүртгүүлэх бүтээгдэхүүний мэдээллийг тодорхой загвар маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх ба тухайн мэдэгдлийг СЗХ өөрийн цахим хуудсанд байршуулснаар бүтээгдэхүүнийг бүртгэсэнд тооцох зохицуулалттай болсон. Мөн журмын хүрээнд даатгалын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд тусгагдсан ба эдгээр шаардлага болон даатгалд хамрагдахтай холбоотой зөвлөмжийг даатгуулагч иргэд, байгууллагуудад хүргүүлж байна.

#### Даатгалын багц дүрмийн хүрээнд даатгалын бүтээгдэхүүнд дараах шаардлага тавигдахыг анхаарна уу.

1. Даатгалын гэрээг монгол хэл дээр үйлдэх;
2. Утга санаа, үг хэллэг нь ойлгомжтой байх, хоёрдмол санаа агуулаагүй байх;
3. Даатгалын гэрээнд дараах нөхцөлүүд тусгагдсан байна:
  - Даатгагч, даатгуулагчийн эрх үүрэг
  - Даатгалын эрсдэл
  - Даатгалын үнэлгээ

- Даатгалын гэрээний хугацаа
- Гэрээг сунгах, цуцлах, өөрчлөлт оруулах нөхцөл
- Даатгалын хураамжийн хэмжээ
- Хураамж төлөх хугацаа, хураамж буцаах нөхцөл
- Гэрээ хүчин төгөлдөр бус болох нөхцөл
- Нөхөн төлбөр олгохоос татгалзах

4. Даатгуулагчийн хүсэлтээр даатгалын гэрээ гадаад хэл дээр байгуулагдсан тохиолдолд тухайн гэрээг монгол хэл дээр давхар үйлдэх зэрэг болно.

#### Даатгагч компани, даатгалын зуучлагч, төлөөлөгчөө сайтар судлах

- Даатгагч компани, даатгалын зуучлагч, төлөөлөгч нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөлтэй эсэхийг анхаарах, даатгалын компани бүтээгдэхүүнүүдээ Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн эсэхийг нягтлах;
- Даатгалын компани даатгалын бүтээгдэхүүнээс сонголт хийх боломжоор даатгуулагчийг хангах үүрэгтэйг анхаарах;
- Даатгалын бүтээгдэхүүнүүд өөр өөрийн онцлог, ялгаатай тул даатгалд хамрагдах болон хасагдах нөхцөлүүд, даатгалын тохиолдол үүсэхэд бүрдүүлэх баримт бичиг, хураамжийн хэмжээ зэрэгтэй сайтар танилцаж, харьцуулж, асууж, зөвлөгөө авах;
- Даатгуулагч даатгалын тохиолдол гарсан бол нэн даруй даатгалын компанидаа мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй бол даатгалын нөхөн төлбөр олгох эсэх талаар гэрээнд заалт байгааг сайн харах;
- Даатгалын хохирол үнэлгээний зардлыг хэн төлөх талаар асууж тодруулах, таны өөрийн буруугаас үүдсэн даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгох эсэхийг тодруулж мэдэх;
- Монгол Улсаас бусад улсад таны даатгал үйлчлэх эсэх зэргийг гэрээний нөхцөлөөс сайтар судлаарай.

#### СЭНДБОКСОД ОРСОН АНХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН АМЖИЛТТАЙ ГАРЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 6 дугаар сард “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг шинээр баталж, 9 дүгээр сараас мөрдөж эхэлсэн. Энэхүү



зохицуулалтын хүрээнд хамгийн анхны нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг “Мобифинанс ББСБ” ХХК-аас гаргасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тус компанийн 1.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг бүртгэсэн. Тус компанийн гаргаж буй өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааг шинэлэг байдлаар зохион байгуулах буюу хөрөнгө оруулагчдад Монпэй аппликейшн /Monpay/ ашиглан худалдахаар болсон нь 2017 онд Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаас хойш цахим мөнгөөр үнэт цаас худалдан авч буй анхны тохиолдол гэдгээрээ онцлог бөгөөд амжилттай хэрэгжүүлэх зорилгоор сэндрбоксоод орох хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд тодорхой цаг хугацаанд турших боломж олгох зохицуулалт бүхий “Сэндрбокс зохицуулалтын орчны журам”-ыг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны ерөнхийлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар баталснаар сэндрбоксын зохицуулалтын орчин бий болсон.

Сэндрбоксын зөвлөлөөс дээрх зохицуулалтын хүрээнд “Мобифинанс ББСБ” ХХК-ийн Монпэй аппликейшнаар дамжуулан нээлттэй гаргах өрийн хэрэгслийг арилжих, хөрөнгө оруулагчдын мөнгө хүсэх өргөдлийг хүлээн авч, эргэн төлөх ажиллагааг сэндрбоксын орчинд турших шийдвэрийг гаргасан нь сэндрбоксоод орсон анхны бүтээгдэхүүн болж байна. Энэхүү шийдвэрийн хүрээнд “Мобифинанс ББСБ” ХХК-аас 11 дүгээр сарын 08-ны өдөр өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааг богино хугацаанд амжилттай зохион байгуулж, 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээ.

### ГАРЫН АВЛАГА ШИНЭЧЛЭГДЭН ГАРЧЭЭ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас өөрийн цахим хуудсанд “Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эрсдэлд суурилсан аргачлалын шинэчилсэн гарын авлага”-ыг нийтэлсэн байна. Гарын авлагад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь эрсдэлд суурилсан аргачлалыг хэрхэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүрэг, ФАТФ-ын зөвлөмж, стандартыг хэрхэн үр дүнтэй биелүүлэх зэрэг асуудлыг тусгажээ.

Мөн улс орны эрх баригчид, санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотойгоор холбогдох хууль тогтоомжид хэрхэн нэмэлт, өөрчлөлт оруулах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан зохицуулалтын болон хяналт шалгалтын тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтын хариу арга хэмжээг ойлгох, боловсруулахад шаардлагатай асуудлыг хөнджээ.



**Гарын авлагад дараах зургаан асуудлыг тодорхойлсон байна. Үүнд:**

- Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тодорхойлолт;
- ФАТФ-ын зөвлөмж нь стэблкоин (stablecoin)-д хэрхэн үйлчлэх талаар;
- Харилцагчаас харилцагчийн хооронд хийгдэж буй гүйлгээ (Peer-to-peer)-нээс үүсэж буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх зөвлөмж, арга хэрэгслийн тухай;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, зөвшөөрөл олгохтой холбоотой шинэчилсэн зөвлөмж;
- Төрийн болон хувийн хэвшилд зориулж улс хоорондын шилжүүлэг хийх зарчим (travel rule)-ыг хэрэгжүүлэх талаарх нэмэлт зөвлөмж;

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хянан шалгагчдын мэдээлэл солилцоо болон хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зарчим.

## БАЙР СУУРЬ

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ АХИЦ ДЭВШИЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛИЙН ҮР ДҮН



*Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөнтэй цөөн хором ярилцлаа.*

#### **Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр гарч буй шинэ зохицуулалтуудын үр дүнд ямар өсөлт хөгжил бий болж байгаа вэ?**

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хувийн хэвшлээс компанийн бонд, анхны арилжааны зориулалттай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /ХБҮЦ/, биржээр арилжаалагддаг хамтын ХОС зэрэг шинэ бүтээгдэхүүнийг гаргах замаар олон нийт, хөрөнгө оруулагчдаас урт хугацааны санхүүжилт татах нь нэмэгдэж, улмаар 2021 оны 3 дугаар улирлын байдлаар нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.1 дахин өссөн бөгөөд компанийн бондын арилжаа 155.7 дахин өссөн. Үүнд Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгох чиглэлээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 550.1 тэрбум төгрөгийн бондын арилжаа голчлон нөлөөлсөн гэж хэлж болно. Тодруулбал, сүүлийн үед хөрөнгийн зах зээл дээр гарч буй ололт, амжилт нь

Санхүүгийн зохицуулах хорооноос цар тахлын үед болон түүнээс хойших хугацаанд хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг хэвээр хадгалах чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалт, мөн хувийн хэвшлээс хамтран ажилласан ажиллагаа үр дүнгээ өгч байгааг онцолмоор байна.

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны зүгээс Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, банкны системд нөлөө бүхий банкнууд хувьцаагаа олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компани болоход бодлогын түвшинд дэмжих зорилгоор холбогдох эрх зүйн зохицуулалтын орчныг тодорхой болгох, шаардлагатай дүрэм, журмыг баталж мөрдүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна. Банкны системд нөлөө бүхий 5 банк, мөн системийн бус нэг банк олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгох ажиллагаа /IPO/-г хэрэгжүүлэх замаар нээлттэй хувьцаат компани болох ба урьдчилсан төсөөллөөр дотоодын зах зээлээс нийт 620

тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.6 их наяд төгрөгөөр нэмэгдэх хүлээлттэй байна. Банкны тухай хуульд заасан шаардлагын дагуу эдгээр банкнууд 2022 оны 6 дугаар сард багтан нээлттэй хувьцаат компани болсноор Монгол Улсад нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 10 их наяд төгрөгт хүрнэ гэсэн өндөр хүлээлт зах зээлд оролцогчдын дунд байна. Нөгөөтээгүүр, банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд банкнууд олон нийтэд хувьцаагаа санал болгож, шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлэх замаар нээлттэй хувьцаат компани болоход тухайн үнэт цаас гаргагч банк, түүнтэй гэрээ байгуулсан андеррайтерийн компанийн хамтын үйл ажиллагааны үр дүн, тэдгээрт хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлсэн мэргэжлийн болон стратегийн хөрөнгө оруулагчид, олон нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ, зах зээлийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг гэдгийг онцлох нь зүйтэй.

**Үнэт цаасны бүртгэлийн журмын шинэчилсэн найруулга болон компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмыг баталснаар хөрөнгийн зах зээлд оролцогчдод өмнө нь боломжгүй байсан ямар боломжууд нээгдэж, ямар асуудлуудыг шийдвэрлэсэн бэ? Энгийнээр тайлбарлавал?**

Улсын Их Хурлаас “Зээлийн хүүг бууруулах стратеги”-г 2020 онд баталсан. Уг стратегид Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авахыг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар компанийн хувьцаа болон өрийн хэрэгслийг нийтэд санал болгон гаргахтай холбоотой харилцааг хамтад нь зохицуулж байсан нь зарим талаар зохицуулалтын давхардлыг үүсгэж байсан. Улмаар Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаар компанийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас болон компанийн өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгон гаргах харилцааг тус тусад нь зохицуулсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулга, “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг тус тус баталсан. Дээрх багц 2 журмыг баталснаар арилжаа эрхлэх байгууллага болон төрийн зохицуулагч байгууллагын хоорондох бүртгэлийн давхардал

арилж, нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны үр ашиг нэмэгдэх, андеррайтер, үнэт цаас гаргагчийн чиг үүрэг, хариуцлага, мэдээллийн ил тод байдал сайжрах, компхувьцаа болон өрийн хэрэгслийн зохицуулалтын давхардал арилж товч тодорхой болох боломж бүрдэхээс гадна хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, түүний тогтвортой байдал, үр ашиг, ил тод байдлыг хангахад чиглэсэн бодлогын томоохон арга хэмжээ болж байгаа юм.

**Дээрх зохицуулалтыг сайжруулснаар ямар тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж байгаа вэ?**

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу хөрөнгийн бирж, зохицуулагч байгууллага хоёрын хоорондын уялдаа холбоог сайжруулж тодорхой болгох шаардлага байсан. Өөрөөр хэлбэл, үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагааны зохион байгуулалт үр ашиггүй бөгөөд олон улсын жишигт нийцээгүй байсан. Уг үйл ажиллагааг олон улсын жишгээр андеррайтерийн компани зохион байгуулахаар болгосон. Өөрөөр хэлбэл андеррайтер нь үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагааг өөрөө удирдаж, хуваарилалтаа хийх ёстой болсон гэсэн үг. Түүнчлэн анхдагч зах зээлд арилжаа амжилтгүй болсонтой холбоотойгоор үүсэх хариуцлагыг андеррайтер өөрөө хүлээнэ. Андеррайтерийн анхдагч болон хоёрдогч зах зээлд гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлага сул байсныг нэмэгдүүлж, олон улсын жишгийн дагуу хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ үүргийг бий болгосон. Ер нь цаашдаа андеррайтерын үйл ажиллагааг чадавхжуулахад чухал нөлөөтэй журам болсон гэж үзэж болно. Нөгөөтээгүүр үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдал, тайлагналтай холбоотой үүрэг, хариуцлага хангалтгүй байсан. Тэгвэл үүнийг Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-ын зарчимд нийцүүлж хугацаат болон тухай бүр ирүүлэх мэдээллийн төрлийг тодорхойлж, маягтжуулалтын тогтолцоог илүү боловсронгуй болгосон.

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгын тухайд гэвэл олон улсын жишгийн дагуу андеррайтерийн компани нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа буюу IPO-г удирдан зохион байгуулж, хувьцааны үнийг зах зээлийн зарчмаар тогтоох, хувьцааны үнийг тогтворжуулах зохицуулалтыг тусгасан бөгөөд ингэснээр нийтэд санал

болгон хувьцаа гаргахтай холбоотой зардал, өртөг буурахаас гадна дотоодын аж ахуйн нэгжүүдээс IPO хийх замаар урт хугацааны санхүүжилтийг хөрөнгийн зах зээл дээрээс татах сонирхол нэмэгдэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо өсөх боломж бүрдсэн. Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдал, компанийн засаглал, санхүү, тайлагналын тогтолцоог сайжруулж, мэдээллийн төрлийг нарийвчлан тогтоон маягтжуулсан бөгөөд нийтэд санал болгон үнэт цаас гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг аудит, хууль, хөрөнгийн үнэлгээний компаниудад тавигддаг шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн нэмэгдүүлж, тэдгээрийн хараат бус байдал болон үйлчилгээний чанарыг өсгөсөн. Харин “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын хувьд гэвэл арилжаа эрхлэх байгууллагын I ангилалд хувьцаа нь бүртгэлтэй, эсхүл Засгийн газар, МҮХАҮТ-ын шалгаруулсан Top-100 ААН болон бусад этгээдийн гаргах бондыг бүртгэх асуудлыг богино хугацаанд буюу СЗХ ажлын 10 хоногт бүртгэх зохицуулалтыг бий болгосон. Түүнчлэн, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор өмнө байгаагүй “Bond Indenture” буюу бонд гаргагч, андеррайтерийн компанийн хооронд байгуулах гэрээтэй холбоотой харилцааг шинээр тусгаснаас гадна бонд гаргагч тодорхой үнийн дүн бүхий бондуудыг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгож, шаардлагатай санхүүжилтийг татах боломж бүхий “Бонд гаргах хөтөлбөр” хэрэгжүүлэх, “Ногоон бонд” гаргах боломжийг бүрдүүлсэн.

### **Өөр бусад журмын зохицуулалтын ямар шинэчлэл байгаа вэ?**

Олон улсын хөрөнгийн зах зээлийн интеграцад нэгдэх, гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг дотоодын биржид давхар бүртгэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-д хөрөнгө оруулагчид дотоодын болон гадаадын биржүүдийн хооронд үнэт цаасаа чөлөөтэй хөрвүүлэн арилжаалах зохицуулалтыг бий болгож, өмчлөх эрхийн бүртгэлийн холимог тогтолцоог бий болгосон. Дээрх журмын шинэ зохицуулалтын хүрээнд Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эрдэнэс Ресурс Девелопмент Корпорэйшн” хувьцаагаар Монголын хөрөнгийн биржид давхар бүртгүүлсэн ба мөн Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Степ Голд” компани хувьцаагаа давхар бүртгүүлэх зөвшөөрлийг тус Санхүүгийн зохицуулах хорооноос авч, анхдагч зах зээлд

олон нийтэд санал болгох ажиллагаагаар энд онд багтаан хэрэгжүүлэх төлөвтэй байна. Азийн хөгжиж буй болон хөгжингүй хөрөнгийн зах зээлтэй орнуудад түгээмэл хэрэглэгддэг хадгаламжийн бичгийг хөгжүүлэх чиглэлээр Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих журмыг шинэчлэн боловсруулж, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 757 дугаар тогтоолоор батлуулсан. Ингэснээр гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй, олон улсын нэр хүнд бүхий компаниудын хувьцаанд суурилсан хадгаламжийн бичиг дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж эхлэх боломж бүрдэхээс гадна шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо болон хөрөнгийн бирж хоорондын үнэт цаасны арилжаа өсөх, улмаар хил дамнан арилжааны дэд бүтцийн орчин нөхцөл сайжирч Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Түүнчлэн, хувьцаат компаниудын ногдол ашгийг жижиг хувьцаа эзэмшигч нарт чирэгдэлгүй хурдан шуурхай тараах ажиллагааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкны дансанд байршуулах зохицуулалтыг бий болгож, хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахим хэлбэрээр зохион байгуулах, жижиг хувьцаа эзэмшигч өөрсдийн төлөөллийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулах зохицуулалтыг бий болголоо.

Цаашид Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, эрх зүйн зохицуулалтын орчныг сайжруулах чиглэлээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад татварын тухай хуулиудад нэн шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах, санхүүгийн технологид суурилсан, санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд ашиглагддаг бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох бодлогыг баримталж, улмаар мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагчдын тогтолцоог бүрдүүлэх, олон улсын нийтлэг жишиг болон бусад Азийн улсын туршлагад үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-г хувьчлах ажлыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан үе шаттай хэрэгжүүлэх, мөн дотоодын томоохон аж ахуй нэгжүүдийг олон нийтэд санал болгон хувьцаа гаргах /IPO/ ажиллагааг хэрэгжүүлж, нээлттэй ХК болоход бодлого, зохицуулалтаар дэмжин төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.

## ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

### “ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ЖУРМЫН ТАЛААР

Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орсон.

Дээрх чиглэлийн бодлого стратеги, зохицуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа болгон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүссэн.

Энэхүү ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7-д “мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг тодорхойлсон журам”-ийг батлан мөрдүүлэх зохицуулалтын дагуу, Санхүүгийн зохицуулах хорооны бусад зохицуулалттай салбарын адил төстэй журам заавар, олон улсын туршлага болон манай улсын үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, холбоодыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдгээрийн саналыг судлан үзэж “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 152 дугаар тогтоолоор батлан мөрдүүлж байна.

Иймд дээрх журмын зорилго, бүтэц, зохицуулах харилцааны талаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, холбоод, иргэд олон нийтэд таниулах зорилгоор дараах танилцуулгыг бэлтгэлээ.

#### Журмын төслийн бүтэц, зохицуулах харилцаа

##### Журмын төслийн бүтэц

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн нэгдсэн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам” нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл;
2. Мэргэжлийн холбоонд тавигдах шаардлага.

##### Зохицуулах харилцаа

- “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн нэгдсэн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам” нь дараах харилцааг зохицуулсан. Үүнд:

- Нийтлэг үндэслэл хэсэгт мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журмын зорилго, Монгол Улсад үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн нэгдсэн нэг холбоо ажиллах талаар;
- Мөн шаардлага хангасан мэргэжлийн нэг холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос санамж бичиг байгуулан хамтран ажиллах талаар;
- Мэргэжлийн холбоонд тавигдах шаардлага хэсэгт холбооны гишүүнчлэл, удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирал тавигдах нөхцөл, холбооноос батлах дүрэм журам, үйл ажиллагаандаа баримтлах зарчмын талаар журмын төсөлд тус тус тусгагдсан.

#### Журмын төсөлд тусгагдсан харилцааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль тогтоомжийн талаар

Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлээс шалтгаалан үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийг хянаж, зохицуулах шаардлага зайлшгүй тулгарч тулгарсан өмнө тус салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг зохицуулдаг, тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллага байхгүйгээр улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж ирсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиглэлээр мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг тодорхойлсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

#### Журам зорилго, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө:

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг журамд тодорхой болгосноор Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоо байгуулагдах цаашид салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөх, гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөрчигдсэн эрхийг хамгаалах институт бий болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байгаа болно.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## НОГООН ДААТГАЛ

*Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын газрын мэргэжилтэн Д. Энхмаа*

Ногоон даатгал нь даатгуулагчийг эрсдэлд ороход нөхөн төлбөр олгон хамгаалахаас гадна байгаль орчинд ээлтэй орчныг бүрдүүлэхэд дэмжин хамгаалдаг даатгалын төрөл юм. Уг даатгал нь уламжлалт даатгалын системээс хураамжаасаа байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад хандив өгөх, даатгуулагчдыг байгаль орчинд ээлтэй, дахин ашиглаж болох материал ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах зэрэг хөшүүрэг ашигладгаараа ялгаатай.

Дэлхийн цаг уур дулаарч байгаагаас үүдэн далайн түвшин нэмэгдэж, хар салхи, үер, салхи шуурганы давтамжийг нэмэгдүүлж байна. Дэлхий дахинаа нүүрстөрөгчийн үйлдвэрлэлийг боломжийн хэрээр хязгаарлаж, цаг агаарын халуун уур амьсгалд бэлтгэх ёстой болоод байна. Сүүлийн жилүүдэд улс орнуудын даатгагчид уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн хариу арга хэмжээ авах талаар бодох шаардлагатай болсон. НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилгод даатгалын компаниуд нэгдэж, байгаль орчинд ээлтэй ногоон даатгалын бүтээгдэхүүний үйл ажиллагаа явуулах хүрээ тэлэгдсээр байна. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гарах зардлыг бууруулах, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах стратеги гарган ажиллах болсон. Ингэснээр даатгалын компаниуд ногоон даатгалын бүтээгдэхүүнийг шинээр гаргаснаар даатгуулагчдын экологийн ул мөрийг багасгахад хувь нэмрээ оруулах юм. Олон улсад дараах ногоон даатгалын төрлүүд байна. Үүнд:

### **Автотээврийн хэрэгслийн ногоон даатгал:**

Энэ төрлийн даатгал нь машинаараа хэдэн километр явснаасаа хамааран даатгалын хураамжаа төлдөг тул байгаль орчинд ээлтэй даатгалд хамаарна. Нийтийн тээврийн хэрэгслээр явах, ойрын зайнд алхах, дугуйгаар явах зэргээр машин унах хэрэглээгээ багасгах тусам төлөх хураамж буурдаг. Ингэснээр экологийн ул мөр багасах, хүлэмжийн хийн ялгарал буурснаар дэлхийн дулаарал удаашрах давуу талтай.

### **Бизнесийн ногоон даатгал:**

Бизнес эрхлэгчийн барилга чанаргүйдснээс үүдэлтэй дахин барих гэж байгаа нөхцөлд эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг ашиглах, ногоон материал ашигласан тавилга, эд хогшил худалдан авах, барилга бүрэн нурснаас үүдэлтэй байгаль орчинд ээлтэй стандартаар дахин барихыг

сэдэлжүүлдэг даатгал. Барилга, байгууламж барихаас гадна байгаль орчинд ээлтэй оффистой байх хөшүүргийг мөн энэ төрлийн даатгалд ашигладаг. Тухайлбал, түлшээр ажилладаг машины оронд цахилгаан автомашин сонгох, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах зэрэг юм.

### **Байгаль орчинд ээлтэй орон байрны даатгал:**

Орон байр засварлахдаа байгаль орчинд сөрөг нөлөөтэй материал сонгохын оронд дахин боловсруулагдахуйц материал ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгслийг худалдан авах даатгал. Хэрэв аль хэдийнээ нарны эрчим хүч ашиглаж эхлээд, дахин боловсруулагдахуйц материал ашиглаж байгаа бол үүнд зориулсан нөхөн төлбөрийн даатгалыг мөн гаргасан. Тус даатгал нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн худалдан авахад өндөр төлбөртэй нөхцөлд нөхөн төлбөр олгодог.

### **Аялал жуулчлалын ногоон даатгал:**

Аялал зугаалгад явахдаа ч байгаль орчинд ээлтэй байх сонголтыг хийх боломжтой. Ялангуяа онгоцоор нисэх нь байгаль орчны доройтолд нөлөөлдөг. Байгаль орчинд ээлтэй аяллын даатгалаар дамжуулан экологийн ул мөрөө бууруулах боломжтой. Уг хураамжаас мөн адил ойжуулалтад хөрөнгө оруулдаг байна.

### **Ногоон урт хугацаатай даатгал:**

Урт хугацааны даатгалын компаниуд нь даатгалын хураамжаас байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад хандив өгөх замаар даатгуулагчдынхаа экологийн ул мөрийг бууруулдаг.

### **Байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн даатгал:**

Эрүүл мэндийн даатгал шууд байгаль орчны асуудалтай холбогддоггүй ч хураамжаасаа ойжуулалт зэрэг байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд хандивладаг.

Даатгалын салбарын тогтвортой хөгжлийг дэмжих өөр нэг арга нь хөрөнгийн зах зээлийн хувьд мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүрэгтэйгээр оролцдог тул хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Учир нь даатгалын салбарт 31.0 их наяд долларын нөөц сангийн хөрөнгийн хөрөнгө оруулалт хийгддэг байна. Олон улсад даатгал нь мэргэжлийн хөрөнгө оруулагч талаасаа тогтвортой хөгжилд дараах байдлаар хувь нэмрээ оруулдаг. Үүнд:

- Хүртээмжтэй санхүүжилт, эрүүл мэнд
- Уур амьсгал болон байгалийн гамшигт уян хатан дэд бүтэц
- Тогтвортой хөдөө аж ахуй ба ойжуулалт
- Ногоон барилга, хүлэмжийн хийн бага эсвэл тэг ялгаралттай тээврийн хэрэгсэл
- Тогтвортой ус болон хог хаягдлын менежмент

Олон улсад даатгалын компани болон тэдний санал болгож буй эрсдэлээс хамгаалах түвшнээс хамааран ногоон даатгал нь ердийн даатгалтай харьцуулахад илүү үнэтэй байж болдог байна. Учир нь байгаль орчныг хамгаалах үнэтэй байдаг ч зарим даатгалын компаниуд өөрсдийн нэр хүндийг сайжруулахыг хүсэж, даатгуулагчдаас өндөр даатгалын хураамж авахгүйгээр байгаль орчны хөтөлбөрүүдэд их хэмжээний мөнгө зарцуулах, байгаль орчныг хамгаалахад оролцохыг хүсдэг байна.

#### Ногоон даатгалын давуу талууд:

- Бидний хүрээлэн буй орчинд эерэгээр нөлөөлнө
- Олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлнэ
- Цэвэр ухамсар

#### Ногоон даатгалын сул талууд:

- Илүү үнэтэй байх боломжтой
- "Ногоон" гэж зарласан даатгал бүхэн ногоон эко байдаггүй
- Ердийн даатгалтай харьцуулахад сул талтай

Ногоон даатгалын бүтээгдэхүүн нь экологийн ул мөрийг багасгах, хойч үедээ амьдрах таатай ирээдүйг хангахад чухал ач холбогдолтой. Олон улсад хөдөө аж ахуйн даатгал, гэнэтийн эрсдэл, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх даатгалын бүтээгдэхүүнүүд олноор гаран өндөр эрэлттэй байгаа хэдий ч бага орлоготой өрхүүдэд зориулсан байгаль орчинд ээлтэй бичил даатгалын бүтээгдэхүүн цөөн байгаа бөгөөд дэлхийн хэмжээнд бичил даатгалын үйлчилгээ хэрэглэгчдийн 85 хувь нь Ази, 10 хувь нь Латин Америк, 5 хувь нь Африкийн даатгалын зах зээлд байна.

1) Филиппин улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлээс хамгаалах зорилготой бичил даатгалын үйлчилгээ нэвтэрсэн бөгөөд уг даатгалыг сүм хийд, мэргэжлийн холбоод зэрэг нийгмийн бүлэг нь эрсдэлээ тархах зорилгоор хамтран ашиглаж байна. Энэхүү даатгалын үйлчилгээ нь байгалийн гамшигт нэрвэгдэх магадлал өндөртэй, гамшигт үзэгдлээс хамгийн их хохирол амсаж болзошгүй бага орлоготой, эмзэг бүлгийн иргэдэд чиглэн хэрэгжиж байгаа нь ногоон даатгалын бүтээгдэхүүний амжилттай жишээ юм.

2) Хонг Конг улсын хувьд Санхүүгийн Холбоо нь "Ногоон ба тогтвортой даатгал"-ын ажлын хэсэг байгуулсан бөгөөд энэ

нь бусад ногоон санхүүгийн үйлчилгээг дэмжих, зохицуулахад чиглэгдсэн албан журмын ногоон даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилготой бөгөөд байгаль орчин, нийгэм, засаглалын тайлангийн шаардлага болон тогтвортой хөгжлийн зорилтуудтай.

Энэхүү ажлын хэсэг нь ногоон даатгалын хөгжлийг дэмжих зорилгоор "Ногоон даатгалын зарчмууд" удирдамжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн зарчимд тулгуурлана. Үүнд:

**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох** – Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, хариу арга хэмжээ авахад байгууллага, олон нийтийг дэмжих зорилгоор даатгал, эрсдэлийн инженерчлэл, андеррайтерийн үйл ажиллагааг боловсруулах

**Байгаль орчны хохирол, бохирдол** – Уг зарчим нь байгаль орчинд хохирол учруулсныг төлөх ба учирсан хохирлыг арилгах шаардлагатай. Ногоон даатгал нь энэхүү эрсдэлийг удирдах, шилжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх шаардлагатай болно.

Сэргээгдэх, дахин боловсруулах эрчим хүчний хэмнэлт – Даатгуулагчдын өөрчлөгдөж буй хэрэгцээнд дасан зохицохын тулд эрсдэлийн чадавхыг төлөвлөх, эрэмбэлэх, эдгээр салбарын шинэ хамрах хүрээ багтана.

**Хөрөнгө оруулалт, хөрөнгийн менежмент** – Ногоон төслүүдэд хангалттай хөрөнгө хуваарилагдахын тулд даатгалын хөрөнгө оруулалтыг ногоон салбарт чиглүүлж, төвлөрүүлэх.

*Мөн уг зарчим нь дараах гол бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:*

Даатгалын хураамжийн хэрэглээ, удирдлага – даатгуулагчдын төлсөн хураамжийг хуванцар орлуулагч, чулуужсан түлш солих, хог хаягдлыг бууруулах үйл явц/шийдэл зэрэг шинэ технологи зэрэг гэрчилгээжсэн ногоон хөрөнгийн ангилалд оруулах.

Даатгуулагч, төсөл сонгон шалгаруулах үйл явц – Байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлдэг, "Ногоон" сертификаттай, "Ногоон эдийн засаг"-ийг дэмжсэн зөвхөн брокер, даатгуулагчидтай хамтран ажиллах.

Бизнесийн үйл ажиллагаа – Эрчим хүчний хэмнэлттэй, нүүрстөрөгчийн ул мөр, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах үйл ажиллагаа эрхлэх.

Андеррайтерийн загвар – Даатгагчид эрсдэлийн загвартаа уур амьсгалын өөрчлөлт болон нүүрстөрөгчийн үнэ цэнийг тооцох шаардлагатай. Энэ нь хүрээлэн буй орчныг сүйтгэж, бохирдуулж байгаа салбаруудын эрсдэлийг тооцоолох.

Бүтээгдэхүүний хөгжүүлэлт – Нүүрстөрөгч багатай эдийн засаг, байгаль орчинд ээлтэй шинэ технологи руу шилжих боломжийг олгодог даатгалын тусгай шийдэл, бүтээгдэхүүнийг бий болгож даатгалын зах зээлд нийлүүлэх.

Санхүүгийн тайлан, тодруулга – Даатгагчдын үйл ажиллагааны төгсгөл хүртэл тайлагнах чадварыг харгалзан үзэх.

3) Солонгос улсын хувьд байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлчилгээнд зориулсан ногоон даатгалыг нэвтрүүлж эхлээгүй бөгөөд олон улсын байгууллагуудын зөвлөмжийн дагуу судалгааны түвшинд ажиллаж байна. Солонгос дахь Европын худалдааны танхимын Даатгалын хорооноос "Үйлдэл хийх цаг: Солонгосын даатгалын салбарын тогтвортой байдал" тайланг 2021 онд нийтэлсэн бөгөөд нийтлэлээр тус хороо нь Европын даатгалын салбарын үүднээс тогтвортой байдлын талаарх ойлголтоо хуваалцаж, Солонгосын ногоон эдийн засаг руу чиглэсэн тайлан гаргасан.

"Тогтвортой эдийн засагт шилжихэд даатгалын салбар гол үүрэг гүйцэтгэнэ. Иймд тус хороонд ажиллаж буй хамтран ажиллагсадтайгаа эдгээр сэдвээр хуваалцсан туршлагаа нэгтгэж, энэ нийтлэлд нийтлэг мэдлэгийг бий болгоход таатай байна. Тогтвортой байдлын сэдэв нь дангаар нь шийдэхэд хэтэрхий том, төвөгтэй. Иймд хамтын ажиллагаа, мэдлэг хуваалцах хүрээнд Солонгосын тогтвортой байдалд хувь нэмрээ оруулахыг тэсэн ядан хүлээж байна." гэж Солонгос дахь Европын худалдааны танхимын Даатгалын хорооны дарга, Солонгос дахь Swiss Re салбарын захирал Jonas von Oldenskiöld дээрх тайландаа дурджээ.

Тус тайлангаар Солонгосын даатгалын салбарт энэхүү байгалийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийн хэв маяг, төрлүүдийг нэмэх бүрэн боломжтой бөгөөд хэрхэн нөлөөлж байгааг судалснаар эцсийн дүндээ даатгалын компаниудын инновац хийх, дасан зохицох чадварыг нэмэгдүүлнэ. Даатгалын компаниуд ногоон барилга гэх мэт нүүрстөрөгчийн хий багатай байх бүтээгдэхүүн үйлчилгээний даатгалын хураамжийг андеррайтинг хийхдээ тодорхой

хэмжээний хөнгөлөлт үзүүлэх, урамшуулах боломжтой тухай тусгасан бөгөөд дараах арга хэмжээг авахыг зөвлөсөн. Үүнд:

**Салбарын бодлогын стандартыг бий болгох:** Даатгалын салбарын удирдамж нь хүчин чармайлт гаргах, шинийг эрэлхийлэх гол эхлэлийн цэг юм. Солонгост байгуулагдсан аж үйлдвэрийн холбоодоор дамжуулан Солонгосын даатгалын зах зээлийн өвөрмөц онцлогт тохируулан нэвтрүүлж, сайжруулж, өөрчлөх боломжтой.

**Ил тод байдлыг эрхэмлэх:** Энэхүү арга хэмжээ нь даатгалын үйл ажиллагаанд оролцогч талуудад нээлттэй мэдээлэх бөгөөд зөвлөмж, санхүүгийн нөлөөллийн шинжилгээ зэрэг орно.

**Бүтээгдэхүүн боловсруулах:** Уур амьсгалын өөрчлөлт, түүнтэй холбоотой эдийн засгийн шилжилттэй холбоотой шинэ бүтээгдэхүүн боловсруулж, санал болгох нь даатгалын салбарын хувьд зайлшгүй хийх ёстой зүйл юм. Шинэ бүтээгдэхүүнүүд нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй алдагдлаас урьдчилан сэргийлэх шийдэл, бүтээгдэхүүнийг бий болгоход чиглэгдэх бөгөөд даатгуулагчид, засгийн газар болон өөрсдийнхөө хувьд алдагдлыг бууруулна.

**Зохицуулалт болон стресс тест:** Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх ерөнхий төлөвлөгөөг дэмжих нь чухал ч даатгалын компаниуд зохих эрсдэлийг дааж, эдгээр аюулыг урьдчилан таамаглах хэрэгтэй. Бусад улс орнуудад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг тухайн компани болон тухайн салбарт бүхэлд нь хэмжих зорилготой уур амьсгалын стресс тестийн хэрэглээ нэмэгдэж байна. Энэхүү аргачлал нь санхүүгийн байгууллагууд болон эдийн засгийн өдөр тутмын үйл ажиллагаа, төлбөрийн чадвар ба хөрвөх чадварын асуудлууд, засгийн газар болон санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн байгууллагуудын хооронд уялдаа холбоотой байх замаар түр зуурын цочролыг арилгах зорилготой юм.




## ФИНТЕК БА РЕГТЕК

### 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ФИНТЕКИЙН САЛБАРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2021 оны эхний хагас жилийн байдлаар дэлхий даяар нийт финтекийн салбарын хөрөнгө оруулалт 98.0 тэрбум ам.доллар хүрсэн ба нийт 2,456 хэлцэл хийгдэж шинэ амжилт тогтоогоод байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 68.6 тэрбум ам.доллараар буюу 2.8 дахин өссөн байна. Коронавируст халдвар /КОВИД-19/ –ын нөлөөгөөр дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдсэнээр тус салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ ихэссэн гэж үзэж байна.

Зураг. Финтект оруулсан нийт хөрөнгө оруулалт ба нийт хэлцлийн тоо



Дэлхийн Вентур капиталын нийт хөрөнгө оруулалт энэ оны эхний хагаст 52.3 тэрбум ам.доллар хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин өссөн. Тухайлбал Вентур капиталын хөрөнгө оруулалтыг харвал АНУ-д төвтэй Wealthtech Robinhood /3.4 тэрбум ам.доллар/, Бразилд төвтэй дижитал Nubank /1.5 тэрбум ам.доллар/, Шведэд төвтэй BNPL фирм Klarna /1.9 тэрбум ам.доллар/, Германд төвтэй Wealthtech Trade Republic /900.0 сая ам.доллар/ зэрэг компаниуд хамгийн их хөрөнгө оруулалт авсан бол Өмнөд Солонгост төвтэй Toss гар утасны санхүүгийн хэрэглүүр 410.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт авснаар Азидаа тэргүүлж байна.

Зураг. Вентур капиталд оруулсан нийт хөрөнгө оруулалт ба хэлцлийн тоо



#### Финтекийн цаашдын хандлага:

**Крипто нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг хамгийн ихээр татна.** 2021 оны эхний хагас жилд блокчэйн ба криптогийн салбарт хөдөлгөөн ихтэй үе байлаа. Салбарын мэргэжилтнүүдийн таамаглаж байгаагаар 2021 оны хоёрдугаар хагаст энэхүү тренд үргэлжлэх ба криптовалютаас эхлээд NFT арилжих платформ зэрэг криптогийн экосистемийг дэмжихэд илүү анхаарна гэж үзэж байна.

**Нэгдэж, нийлэх /merge and acquisition M&A/ үйл ажиллагаа өссөөр байна.** Байгууллагууд өөрсдийн чадавхыг нэмэгдүүлж, старт-ап компаниуд технологийн шинэ шийдлүүдийг гаргаж ирсээр байх хандлагатай тул нэгдэж нийлэх үйл ажиллагааны хувьд өсөлтөө хадгална гэж үзсэн. Түүнээс гадна финтек компаниуд томрох үйл явц эрчимтэй явагдаж байгаа нь хил дамнанас үйл ажиллагаа ч мөн адил өсөх төлөвтэй байна.

**SPAC /Special Purpose Acquisition Company – Тусгай зориулалтын худалдан авалтын компани/–ууд анхаарлын төвд орно.** SPAC компани нь шинэлэг санаа, инновацын компанитай нэгдэн, нийлснээр хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг өсгөх үйл ажиллагаа явуулдаг. Зүүн өмнөд Азийн улсуудад үйл ажиллагаагаа явуулдаг Grab компанийн хувьд АНУ дахь Altimeter Growth Corp /SPAC/ байгууллагатай нэгдэх 40.0 тэрбум долларын хэлцэл хийгдсэн тохиолдолд энэ оны онцлох үйл явдал болно гэж харж байна.

**Цахим аюулгүй байдлын асуудлыг илүү чухалчилна.** Дижитал гүйлгээ өсөж байгаатай зэрэгцэн цахим халдлага, вирусийн дайралтын үйл ажиллагаа ихэссэн байна. Иймд цахим аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх хандлага өндөр байна.

**Финтекийн салбар хоорондын B2B үйлчилгээ ихэснэ.** B2B үйлчилгээг зөвхөн төлбөр тооцооны зах зээлд биш иншуртек /insurtech/, хөрөнгийн удирдлагын технологи /wealthtech/, рэгтек /regtech/–үүдэд ашиглаж буй байгууллагуудад хөрөнгө оруулалт хийгдэнэ гэж үзжээ.

## Судлаачийн индэр

### АРИЛЖААНЫ БАНКНУУДЫН ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### Гүйцэтгэсэн:

МУИС-ийн Банкны хөтөлбөрийн 4-р түвшний оюутан Ц.Энхбаяр

МУИС-ийн Аудитын хөтөлбөрийн 3-р түвшний оюутан Б.Номуун

#### НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улс 2021 онд банкны салбарт бий болж буй томоохон хууль зүйн өөрчлөлтүүд нь системийн хувьд бүх банкнууд дүрмийн сангийн доод хэмжээг 100 тэрбумаар тогтоох, системийн нөлөө бүхий банкнуудын хувьд олон нийтэд хувьцаагаа санал болгох буюу IPO болох, хамгийн их хувьцаа эзэмшигч дүрмийн сангийн 20 хувиас дээшгүй хэмжээний хувьцаатай байх, 5-аас доошгүй хувьцаа эзэмшигчидтэй байх зэрэг өөрчлөлтүүд гарсан билээ. Хадгаламж эзэмшигчид хувьцаа эзэмшигч болох шилжилт нь засаглал олонх болгон сайжруулан эх үүсвэрийн зардал багасах болон банкны эрсдэл даах чадвар сайжрах зэрэг урт хугацааны давуу талтай хэдий ч богино хугацаанд банкандаа эх үүсвэрийн тогтворгүй байдал үүсгэх эрсдэлтэй гэж таамаглал дэвшүүлж энэхүү судалгааны ажлыг бичлээ.

Хүснэгт. Нийт пассивын үзүүлэлтүүд

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТЭМДЭГЛЭГЭЭ
Аж ахуй нэгж, иргэдийн харилцах	1
Аж ахуйн нэгж, иргэдийн хадгаламж	2
Бусад санхүүгийн байгууллагад төлөх өглөг	3
Бусад төрлийн харилцах, хадгаламж	4
Мөнгөний захын хэрэгслүүд	5
Тусгай зориулалттай болон хязгаарлагдмал хадгаламж	6
Бусад банканд төлөх өглөг	7
Төв банканд өгөх өглөг	8
Гадаад пассив	9
Засгийн газарт өгөх өглөг	10
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит бус алдагдал	11
Бусад пассив	12

#### ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Системд нөлөө бүхий банкнуудын олон нийтэд хувьцаа гаргаснаар арилжааны банкнуудын эх үүсвэрийн эрсдэл тооцоодоо системийн нэгдсэн санхүүгийн байдлын тайлан (татан буугдсан банкнууд ороогүй)-гаас үзүүлэлтүүдээс сонгон авч нийт пассивд тоон өгөгдлүүдийг Монголбанкны веб сайтын статистикийн хуудаснаас, банкнуудын өөрсдийн жилийн тайлангуудаас авав. Түүний дараагаар эх үүсвэрийн багцын хүлээж болзошгүй алдагдлын хэмжээг марковицийн сонгодог онолын аргаар тооцоолов. Бид нар зөвхөн Монголоос эх үүсвэрээ татна гэсэн нөхцөлөөр дараах ажлыг гүйцэтгэв. Нийт пассивд:

гэсэн үзүүлэлтүүдийг дараах байдлаар нэгтгэн бүрэлдэхүүн болгон авсан.

Харилцах	1+4
Хадгаламж	2+6
Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	3+7+8
Бусад эх үүсвэр	5+9+11
Бусад өр төлбөр	10+12

Хүснэгт. Пассивын үзүүлэлтүүд

2021 оны 3-р улирлын дүнгүүд		Нийт пассив	
Харилцах	$w_1$	Харилцах	$x_1$
Хадгаламж	$w_2$	Хадгаламж	$x_2$
Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	$w_3$	Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	$x_3$
Бусад эх үүсвэр	$w_4$	Бусад эх үүсвэр	$x_4$
Бусад өр төлбөр	$w_5$	Бусад өр төлбөр	$x_5$

Эндээс ковариацийг олоод түүнийг  $\min$  хэлбэрээр эх үүсвэрийн багцын хүлээх эрсдэл гарч ирнэ.

## ГУРАВ. ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ

### 3.1 Хадгаламж өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөө

Хадгаламжийн өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөөг тооцоход өөрийн хөрөнгийг, нийт хадгаламжийг гэж тэмдэглэе. Тоон үзүүлэлтүүдийн нэгж язгуурыг ADF шалгуурыг ашиглан үзэхэд Хавсралт 1 дэх үзүүлэлтүүд тус бүр тогтворгүй байгааг илэрхийлж байгаа ба хэрэв эдгээрээр үнэлгээ хийвэл хуурмаг регресс үүсэхээр байна. Иймд үзүүлэлтүүдийг хувиргах шаардлага үүсэж байгаа ба логарифм суурь авч ахин ADF шалгуурыг явуулж үзвэл тоон үзүүлэлтүүдийн тренд арилж тогтвортой болж байна.

Хүснэгт. Хувиргасан үзүүлэлтүүдийн ADF шалгуур

	t-Statistic	Prob.*
Augmented Dickey-Fuller test statistic	-3.090330	0.0289
Test critical values:		
1% level	-3.462574	
5% level	-2.875608	
10% level	-2.574346	

\*MacKinnon (1996) one-sided p-values.

	t-Statistic	Prob.*
Augmented Dickey-Fuller test	-12.71527	0.0000
Test critical values:		
1% level	-3.462737	
5% level	-2.875680	
10% level	-2.574385	

\*MacKinnon (1996) one-sided p-values.

Мөн загварын үнэлгээ хийхээс өмнө коинтеграцийн асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай тул Жохансаны тестээр коинтеграцийн шалгуур явуулж үзвэл үзүүлэлтүүд хоорондоо коинтеграц хамааралтай гэсэн таамаглал няцаагдах үндэслэл болохгүй байна.

Хүснэгт. Тоон үзүүлэлтүүдийн коинтеграц шалгуур

Trend assumption: Linear deterministic trend

Series: LOGY LOGX

Lags interval (in first differences): 1 to 4

#### Unrestricted Cointegration Rank Test (Trace)

Hypothesized No. of CE(s)	Eigenvalue	Trace Statistic	0.05 Critical Value	Prob.**
None	0.045771	11.62131	15.49471	0.1760
At most 1	0.011480	2.297802	3.841466	0.1296

Trace test indicates no cointegration at the 0.05 level

\* denotes rejection of the hypothesis at the 0.05 level

\*\*MacKinnon–Haug–Michelis (1999) p–values

#### Unrestricted Cointegration Rank Test (Maximum Eigenvalue)

Hypothesized No. of CE(s)	Eigenvalue	Max–Eigen Statistic	0.05 Critical Value	Prob.**
None	0.045771	9.323504	14.26460	0.2602
At most 1	0.011480	2.297802	3.841466	0.1296

Max–eigenvalue test indicates no cointegration at the 0.05 level

\* denotes rejection of the hypothesis at the 0.05 level

\*\*MacKinnon–Haug–Michelis (1999) p–values

#### Хүснэгт. ХБКА–аарх үнэлгээ

Дээрх шалгууруудаас дүгнэвэл тоон үзүүлэлтүүд тогтвортой, коинтеграц хамааралгүй байгаа тул хамгийн бага квадратын аргаар үнэлэх нөхцөл бүрдэж байна. Уг загвараар тоон үзүүлэлтүүдийн үнэлбэл үр дүн дараах байдалтай байна.

Variable	Coefficient	Std. Error	t–Statistic	Prob.
C	6.663135	0.459046	14.51518	0.0000
LOGX	0.511612	0.028271	18.09652	0.0000
R–squared	0.823892	Mean dependent var		14.96914
Adjusted R–squared	0.821376	S.D. dependent var		0.152157
S.E. of regression	0.064307	Akaike info criterion		–2.622903
Sum squared resid	0.289480	Schwarz criterion		–2.559662
Log likelihood	96.42450	Hannan–Quinn criter.		–2.597727
F–statistic	327.4839	Durbin–Watson stat		0.169731
Prob(F–statistic)	0.000000			

Хэдийгээр детерминацын коэффициент болон үзүүлэлтүүдийн статистик утгууд сайн гарч байгаа хэдий ч Durbin–Watson статистик утга 0–рүү тэмүүлсэн үр дүн гарсан байна. Иймд загварт үлдэгдлийн коррелограмм байгуулан харвал үзүүлэлтүүд авторегрессстэй байгаа нь харагдаж байна. Брьюш–Годфрейн лагранжийн үржүүлэгч шалгуураар давхар шалгаж үзвэл уг шалгуурын  $\chi^2$  болон  $F$  статистикийн утгууд 1 хувийн түвшинд ач холбогдолтой гарч автокорреляцтай байгааг баталж байна.

Хүснэгт. Брьюш–Годфрейн LM шалгуур

Breusch–Godfrey Serial Correlation LM Test:

F–statistic	260.6653	Prob. F(1,69)	0.0000
Obs*R–squared	56.93017	Prob. Chi–Square(1)	0.0000

Үлдэгдлийн коррелограммын АС болон PAC утгуудыг ажиглавал манай загварт ARMA(1,0) загвар ашиглах нь тохиромжтой илтгэж байна. Уг загварын үнэлгээний үр дүнг харвал детерминацын коэффициент, статистик утгууд ач холбогдол өндөртэй, тун сайн үр дүнг үзүүлж байна. мөн загварт авч үзсэн AR(1) үзүүлэлтийн язгуурын тест 1–ээс бага байгаа нь уг үзүүлэлт тогтвортой байгааг илтгэж байна.

Хүснэгт. ARMA загварын үр дүн

Variable	Coefficient	Std. Error	t–Statistic	Prob.
C	9.282861	1.710842	5.425901	0.0000
LOGX	0.348003	0.105122	3.310457	0.0015
AR(1)	0.959035	0.046481	20.63286	0.0000
SIGMASQ	0.000645	8.36E–05	7.718017	0.0000

R–squared	0.971752	Mean dependent var	14.96914
Adjusted R–squared	0.970506	S.D. dependent var	0.152157
S.E. of regression	0.026131	Akaike info criterion	–4.362400
Sum squared resid	0.046432	Schwarz criterion	–4.235919
Log likelihood	161.0464	Hannan–Quinn criter.	–4.312048
F–statistic	779.7624	Durbin–Watson stat	1.885800
Prob(F–statistic)	0.000000		

Inverted AR Roots .96

Дээрх үр дүнг тэгшитгэл хэлбэрээр дараах байдлаар бичиж болно.

$$\log(y) = 9.283 + 0.348 * \log(x) + 0.959$$

Дээрх үр дүнгээс харахад хадгаламж өсөхөөр байгаа тул бидний хувьд хадгаламж нэг нэгжээр буурахад  $\log(0.35)$  хэмжээгээр буурах нь харагдаж байна.

Хадгаламж; Харилцах; Банк санхүүгийн байгууллагуудаас татсан эх үүсвэр; Бусад эх үүсвэр; Бусад өр төлбөр суурь дүнгээс өмнөх дүнгээ хасаад өмнөх дүнд хувааж өгснөөр өсөлтийн хувийг (Жишээ нь  $\frac{2004Q2-2004Q1}{2004Q1}$  хуваагаад бүх өсөлтийн жинг олно) нь олж ковариаци олоход дараах байдлаар гарч байна.

	Өөрийн хөрөнгийн дүн-Е	Хүлээх эрсдэл-У	Е/У
Хаан банк	1,298,249	627,445.6	2.07
ХХБанк	1,094,688	477,724	2.29
Голомт банк	591,681	592,276.7	1.00
Хас банк	381,395	122,308	3.12
Төрийн банк	384,368	177,010	2.17

Дээрх тэгшитгэлээс харахад  $\frac{\text{Өөрийн хөрөнгө}}{\text{Хүлээх эрсдэл}} * \frac{\text{Хүлээх эрсдэл}}{\text{Эрсдэлээр жигнэгдсэн актив}} \geq 12\%$  Үүнээс Хаан банкны хувьд Эрсдэлээр жигнэгдсэн активыг тооцоолоход  $\text{Эрсдэлээр жигнэгдсэн актив} \leq 2.07 * \text{Хүлээх эрсдэл}$  Эрсдэлээр жигнэгдсэн актив ийм нөхцөлтэй болно.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Тоон шинжилгээнээс дүгнэхэд банкны системд нийт хадгаламж эзэмшигчдийн 12.3 хувийг хадгаламж эзэмшигчээс хувьцаа эзэмшигч болох эрсдэлтэй гэж үзэж шинжилгээ хийхэд үр дүн нь ТОП-5 банкны олон нийтэд хувьцаагаа санал болгосноор ойролцоогоор эх үүсвэр дэх багц 2 их наяд төгрөг эрсдэхээр харагдаж байна. Хаан банкны эх үүсвэрийн багц нь хамгийн эрсдэлтэй буюу 627,445.6 сая төгрөгөөр эрсдэж байгаа бол үүний дараагаар Голомт банк нь 592,276.7 сая төгрөгөөр эрсдэх магадлалтай байна.

Үүнээс харахад системд нөлөө бүхий банкнуудад болон банкны системийн хувьд банкнуудад ихээхэн хэмжээний эх үүсвэр гаргах ба түүнээсээ Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэмжээг сайжруулах ёстой гэж харагдаж байна.

## ТАВ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ Багц сонголтын онол (Markowitz H. M., 1952)
- ◆ Банкны харилцааны пүүсийн IPO-ийн үнийг бууруулахад үзүүлэх нөлөө (SCHENONE, 2004)
- ◆ Банкны IPO хийхээс өмнөх эзэмшлийн бүтэц, түүний IPO үйл явцад үзүүлэх нөлөө (ROOSENBOOM, 2009)
- ◆ Олон зорилтот шугаман программчлал- (Sealey & Eatman, 1979)
- ◆ Зорилгын программчлал-(Giokas & Vassiloglou, 1991)
- ◆ ARMA загварыг тодорхойлох (Choi, 1992)
- ◆ Augmented dickey fuller test (Mushtaq, 2011)



## ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БА ЭРГЭН ТӨЛӨЛТ

**Зээлийн гэрээ гэдэг нь:** зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан мөнгийг тохирсон хугацаанд, хүүтэй буцаан өгөх үүргийг тусгасан баримт бичиг юм.

Зээлийн бүтээгдэхүүний талаар дэлгэрэнгүй СУДЛАХ

Яаран гарын үсэг зурахаас өмнө зээлийн гэрээгээ сайтар УНШИХ



Ойлгохгүй заалтын талаар банкны ажилтнаас зөвлөгөө аваарай.

Эргэн төлөлтийн хуваарь нь ирээдүйн орлоготой уялдаж байгаа эсэхийг НЯГТЛАХ

Хүүгийн төлбөр болон гэрээний хариуцлагын талаарх заалтыг АНХААРАХ

### Зээлийн эргэн төлөлтөө:



15–90 хоног хэтрүүлсэн бол : анхаарал хандуулах буюу хугацаа хэтэрсэн  
91–180 хоног : хэвийн бус  
181–360 хоног: эргэлзээтэй  
361–ээс дээш хоног хэтрүүлсэн бол муу зээл болно.

“Хэрхэн ухаалаг зээл авах” талаар **ЗУРАГТ ХУУДАС №1**–ээс мэдээлэл аваарай.



“Хар жагсаалт” буюу “Зээлийн мэдээллийн сан”-д хэвийн бус, эргэлзээтэй, муу зээлүүд бүртгэгддэг ба зээлээ барагдуулж дууссанаас хойш 6 жилийн хугацаанд бүртгэлтэй хэвээр байдаг.

Бүх санхүүгийн байгууллагууд нэгдсэн зээлийн мэдээллийн сангаас таны мэдээллийг авдаг гэдгийг санаарай.

## ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР



Би зээлийн эргэн төлөлтөө ямар хэлбэрээр төлж болох вэ?


Таны орлогын эх үүсвэрээс хамааран дараах хувилбаруудыг санал болгож байна

■ Зээл     
 ■ Хүүгийн төлбөр     
 1-р сар    2-р сар    ..... сүүлийн сар

01

**Сар бүрийн тэнцүү төлбөр**


/тогтмол цалинтай болон тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/



02

**Сар бүр тэнцүү үндсэн зээлийн төлбөр**


/тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/



03

**Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлээ хувааж төлөх**

/улирлын шинж чанартай тогтмол бус орлоготой бизнес эрхлэгчдэд/



04

**Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, бусад хугацаанд зээлийн төлбөр тэнцүү**

/улирлын шинж чанартай тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### 2021 ОНЫ КОМПАНИЙН УДИРДЛАГУУДЫН СУДАЛГАА

Корпорацийн ертөнц байнга тогтворгүй байгаатай зэрэгцээд сүүлийн жилүүдэд янз бүрийн сорилтууд гарч ирж байна. Ковид-19 тахал нь дэлхийн хэмжээнд урьд өмнө хэзээ ч байгаагүй үр нөлөөг бий болгоод байна. Хөдөлмөрийн зах зээл чангарахаас өмнө хөрөнгийн зах зээл түүхэн дээд хэмжээнд хүрч, зээлийн хүү түүхэн доод хэмжээндээ хүрч, ажилгүйдлийн тоо огцом өссөн. Үүнтэй зэрэгцэн нийгмийн шударга ёсны асуудал ч газар авчээ. 2020 онд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах шударга ёсны төлөөх эсэргүүцлийн жагсаал улс орон даяар өрнөж, өнөөгийн тэгш бус байдал болон өмнөх алдаануудыг хэрхэн шийдвэрлэх тал дээр байнгын анхаарал хандуулж байна.

Хэрэглэгчид болон үйлчлүүлэгчид компаниудыг нийгмийн асуудалд шинэ арга замаар оролцож, олон нийтийн санаа зовоосон асуудлаар (нийгмийн шударга ёсны асуудал, уур амьсгалын өөрчлөлтийн хурд, үр нөлөөг бууруулах үүрэг зэрэг) мэдэгдэл хийж, бодлого боловсруулахыг хүлээж байна.

Дээр дурдсан өөрчлөлтүүд маш өргөн хүрээнд буюу ажилчдаас эхлээд удирдах албан тушаалтнууд болон ТУЗ хүртэл нөлөө үзүүлж байна. ТУЗ-үүд зарим талаараа компанийн тогтворжуулах хүчин болдог учраас төдийлөн өөрчлөгддөггүй ч дэлхий ертөнц өөрчлөгдөж байгаатай зэрэгцээд тоглоомын дүрмээ өөрчлөх зайлшгүй шаардлагатай тулгарсан.

Олон талт байдал, хүртээмж (D&I) хүчин чармайлт нь компани болон удирдах зөвлөлд аль алинд нь хамааралтай гэдгийг ойлгож, харьяалагдах соёлыг бий болгох шаардлагатай байдаг. Илүү сайн, тогтвортой бизнесийн үр дүнд хүрэхийн тулд удирдлагууд ESG (Байгаль орчин, нийгэм засаглалын асуудал) болон компанийн үндсэн стратеги хоорондын уялдаа холбоог улам бүр олж харах хэрэгтэй. Хөдөлмөрийн зах зээл хязгаарлагдмал хэвээр байгаа тул компаниуд ирээдүйн ажлын байрны асуудлыг дахин төлөвлөж байна.

Удирдлагууд ажиллах хүчээ зөв сонгох, ирээдүйн авьяас чадварыг удирдах стратегийг боловсруулах зэрэг шийдвэрт илүү оролцох шаардлагатай гэж үзэж байна. Эдгээр бүх хүнд хэцүү асуудлуудыг даван туулахын тулд ТУЗ-ийн үр нөлөө маш чухал бөгөөд ирээдүйн байр сууриа хамгаалахын тулд

компанийн удирдлагуудын бараг тал нь удирдах зөвлөлдөө өөрчлөлт хийхийг хүсэж байна.

Компаниудад үзүүлж буй нийгэм, байгаль орчин, эдийн засгийн дарамт үргэлжилсээр байгаа тул удирдлагууд өөрчлөлт хийхэд бэлэн байх хэрэгтэй.

#### Төлөөлөн удирдах зөвлөлийн анхаарлаа хандуулах асуудлууд

Засаглал, ТУЗ-ийн хяналтыг сайжруулах ажил төдийлөн хийгдэхгүй байна гэж үзэж байна. Төлөөлөн ТУЗ-ийн анхаарлаа хандуулахыг уриалж буй зургаан чиглэлийг энд оруулав.

#### ESG хяналтад илүү их цаг хугацаа, нөөцөө зориулах

Судалгаагаар ESG нь хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийн удирдлагуудтай хэлэлцэхийг хүсдэг хамгийн чухал асуудал бөгөөд энэ нь ТУЗ-ийн хяналтын чухал хэсэг юм. Гэхдээ захирлуудын ердөө 25 хувь нь ESG-ийн эрсдэлийг маш сайн ойлгодог ба үүнийг нэмэгдүүлэх шаардлага бий болсон. Зарим ТУЗ асуудалд анхаарлаа хандуулахын тулд шинэ хороодыг байгуулж байгаа ч энэ нь хангалттай биш юм. Хэлэлцэх асуудалд хангалттай анхаарал хандуулж, цаг гаргаж, ТУЗ-ийн гишүүдэд шаардлагатай боловсролыг олгох нь илүү чухал юм.

#### ESG-г компанийн стратегитай холбох

ESG-н хамгийн чухал хэсэг нь эдгээр урт хугацааны асуудлуудыг компанийн стратегид тусгах явдал юм. Уялдаа холбоог хангах, хэрэгжүүлэх нэг арга бол гүйцэтгэх ажилтны цалин урамшууллыг санхүүгийн бус хэмжүүртэй холбох явдал юм. Энэ санааг дэмжиж байгаа удирдлагуудын тоо нэмэгдэж байгаа ч харьцангуй цөөн компани үүнийг ажил хэрэг болгож байна.

#### Авьяас чадварын менежментийн хяналт, ажлын ирээдүйг нэн тэргүүнд тавих

Ковид-19 тахал болон түүний дараах үр нөлөө нь ажил олгогчдоос ажлын байраа эрс өөрчлөх шаардлагыг бий болгож байна. Авьяас чадварыг хянах нь нарийн төвөгтэй ажил бөгөөд захирлуудын үзэж байгаагаар энэ нь ТУЗ-ийн нэмэлт цаг шаарддаг салбар юм. Өрсөлдөх чадвартай байхын тулд компаниуд шилдэг авьяастнуудыг татах хэрэгтэй. Компанийн ажиллах хүчний стратеги ирээдүйд хэрхэн өөрчлөгдөж болох талаар шийдвэр гаргахад ТУЗ



оролцож, стратеги нь ажиллах хүчний олон талт байдал, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн байх ёстой.

### **Дахин сэргээх замаар ТУЗ-ийн олон талт байдлын асуудлыг шийдвэрлэх**

ТУЗ-ийн олон талт байдал нь шийдвэрлэх шаардлагатай асуудал гэдгийг удирдлагууд ойлгож байгаа ч үүнийг аяндаа засрах асуудал биш гэдгийг ойлгосон. Удирдлагууд олон талт байдлын чиг үүргийг хүлээн авахад одоогоор бэлэн биш байгаа ч зорилго тавьж, дотоод залгамж халааны төлөвлөгөөг бий болгосноор мэдэгдэхүйц сайжруулалт хийж чадна. Бүрэн бүрэлдэхүүнээрээ хоёр, гурав, эсхүл дөрвөн жилийн дараах зорилтыг тодорхойлж, түүндээ хүрэх төлөвлөгөөгөө гаргах нь зүйтэй.

### **ТУЗ-ийн үнэлгээг хоёр дахин бууруулах**

Захирлуудын бараг тал хувь нь (47 хувь) ТУЗ-ийн нэг буюу хэд хэдэн гишүүнийг солих ёстой бөгөөд хангалтгүй гүйцэтгэлтэй, эсвэл удирдах зөвлөлд тохирохоо больсон захирлуудад зориулсан орон зай байхгүй гэж үзсэн байна. Удирдах зөвлөл бүр өөрчилж, сайжруулах боломжтой, авч хэрэгжүүлэх ажлыг тодорхойлохын тулд жил бүр захирлуудад үнэлгээ хийх шаардлагатай байдаг. Төлөөлөн ТУЗ-ийн дарга жил бүр захирал бүртэй ганцаарчилсан

уулзалт хийж, үнэнч, илэн далангүй санал хүсэлтээ хуваалцах ёстой.

### **ТУЗ-ийн тэргүүлэх чиглэлийг дахин тодорхойлох**

ТУЗ-ийн хяналтын аль салбар илүү их цаг, анхаарал шаарддаг гэж асуухад захирлуудын 34% нь авьяас чадварын менежмент гэдэгтэй санал нэг байна. Гэхдээ үүнээс гадна тэд өөр өөр тэргүүлэх чиглэлүүдийг нэрлэсэн. ТУЗ-ийн тэргүүлэх чиглэлийн сэдвээ тодорхойлж, хамгийн түрүүнд анхаарал хандуулах асуудлын талаар зөвшилцөлд хүрэхийн тулд хангалттай цаг гаргаж, хүчин чармайлттай ажиллах хэрэгцээ үүсээд байна.



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



### Криптовалютын зах зээлийн үнэлгээ 3 их наяд ам.доллар давжээ

10,462 криптовалютын ханшийг харуулдаг CoinGecko цахим хуудасны мэдээллээр, Энэ оны 11 дүгээр сарын 08-ны өдөр криптовалютын зах зээлийн нийт үнэлгээ түүхэндээ анх удаа 3 их наяд ам.доллар давсан байна. Тус өдрийн 16:15 цагийн байдлаар 3.7 хувиар өсөж, 3.01 их наяд долларт хүрчээ. 2020 оны жилийн эцсээс криптовалютын зах зээлийн үнэлгээ бараг дөрөв дахин өссөн байгааг "Bloomberg" агентлаг онцолсон. Хөрөнгө оруулагчид биткойныг инфляцаас хамгаалах нэг

хэрэгсэл гэж харах болсон нь түүний ханшийн өсөлтөд бас нөлөөлсөн гэж судлаачид дүгнэсэн.

"Крипто зах зээлийн өсөлт гайхмаар хурдтай байна. Мэдээж тодорхой хэмжээний хөөсрөлт байж болох ч бас тодорхой хэсэг нь бодитой байна. Крипто уламжлалт санхүүгийн ертөнцөд нэвтрэх замаа засаж, бүгд үүнд нэгджээ" гэж SwissQuote байгууллагын шинжээч Айпек Озкардеская хэлсэн байна.

Энэ оны 10 дугаар сард санхүүгийн нэг төрлийн бүтээгдэхүүн болох биткойны фьючерсийн ETF (exchange-traded fund) Нью Йоркийн хөрөнгийн бирж дээр анх удаа арилжаалагдаж эхэлсэн юм. Ингэснээр биткойнд хөрөнгө оруулах боломж улам бүр нээлттэй болсон.

### Биткойны ханш түүхэн дээд үзүүлэлтэд хүрчээ

Дэлхий даяар хамгийн их эрэлттэйд тооцогдож буй цахим валют болох биткойны ханш анх удаа 67 мянган ам.доллар давж, түүхэн дээд үзүүлэлтэд хүрэв.

"CoinMarketCap" цахим хуудасны мэдээллээр, биткойн 7.29 хувиар өсөж, 67.6 мянган долларт хүрсэн бол "Binance" бирж дээр биткойн 7.5 хувиар өсөж, 67.63 мянган ам.долларт хүрсэн.



Өнгөрсөн сар буюу 10 дугаар сард 43.82 мянгаас 61.3 мянган ам.доллар болж, 40 орчим хувиар өссөн байна.

### “Squid Game” криптовалют луйвар байсан нь илэрлээ



10 дугаар сарын сүүлчээр Netflix-ийн “Squid Game” цувралын нэртэй криптовалют зах зээлд нэвтэрч, ханш нь богино хугацаанд асар ихээр нэмэгдсэн. Гэвч 11 дүгээр сарын 01-ны өдөр койныг үүсгэгч этгээд нь эзэмшиж байсан бүх койноо зарж, бэлэн мөнгө болгоод сураггүй алга болжээ.

SQUID койны үнэ 10 дугаар сарын 20-нд эхлэхдээ хэдхэн центтэй тэнцүү байсан ч, \$40 орчимд хүрээд байжээ. Харин уналтын дараа \$0.005-тай тэнцэх болсон байна. SQUID койны ханш ид өсөж байх үед CNBS, Forbes, BBC, Fortune зэрэг томоохон хэвлэлүүд гайхмаар хурдтай өсөлтийн тухай магтан бичсэн нь хүмүүсийн эргэлзээг арилгаж, олон хүн хөрөнгө оруулалт хийх нэг шалтгаан болсон. Тухайлбал Fortune сэтгүүлд “Squid Game’ crypto is up more than 86,000% in a week” гэсэн гарчигтай мэдээ нийтлэгдэж байсан юм.

### Япон Улсын ДНБ 3 хувиар буурчээ

Эдийн засагчид 3 дугаар улиралд ДНБ 0.6 хувиар агшина гэж таамаглаж байсан ч өмнөх улирлаас 0.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 3 хувиар тус тус буурчээ. Үүнд Ковид-19 цар тахлын улмаас тогтоосон онцгой байдал, дэлхий нийтийг хамарсан чип, эд ангийн хомсдолын улмаас автомашины борлуулалт, экспорт саарсан зэрэг нь нөлөөлсөн байна. Засгийн газраас танилцуулсан урьдчилсан мэдээлэлд дурдсанаар, ДНБ буюу улсын хэмжээнд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний дүн анх удаа буурсан үзүүлэлт байна.

Японы олон мужид халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор 10 дугаар сарын 01 хүртэл олон сарын турш онцгой байдал тогтоож, хүмүүсийг гэрээсээ гарахгүй байхыг зөвлөж, зоогийн

газар, цэнгээний газруудын ажиллах цагийг богиносгож, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хязгаарласантай холбоотойгоор хэрэглээний зардал 1.1 хувиар буурсан байна.

Мөн Зүүн Өмнөд Азийн орнуудад Ковид-19 цар тахлын өвчлөл нэмэгдсэний улмаас автомашины эд анги хомсдож, дэлхийн дахинд хагас дамжуулагчийн хомсдол бий болсноор автомашин үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ бууруулахаас өөр аргагүйд хүрсэн юм. Автомашины үйлдвэрлэл буурснаар бизнесийн хөрөнгө оруулалт, экспортын хэмжээ 3.8, 2.1 хувиар тус тус буурсан ба Засгийн газар ДНБ-ий шинэчилсэн мэдээллийг энэ оны 12 дугаар сарын 08-нд танилцуулах төлөвтэй байна.

### Бээжингийн хөрөнгийн бирж үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлжээ



Бээжингийн хөрөнгийн бирж энэ оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэллээ. Уг бирж нь үндсэндээ жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хооронд мөнгөн бус гүйлгээгээр хувьцаа гаргахад зориулагдсан байна. Бээжингийн хөрөнгийн бирж нь үндэсний аж ахуйн нэгжүүдийн инновацийн чадавхыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж БНХАУ-ын эрх баригчид мэдэгдсэн.

Одоогоор хөрөнгийн биржид 80 гаруй компани бүртгэлтэй байгаа ч цаашдаа олноор нэмэгдэх төлөвтэй байна. Энэ худалдааны шинэ платформ нь эдийн засгийн уламжлалт төдийгүй шинэ салбарыг хөгжүүлэхэд түлхэц болно гэсэн хүлээлттэй байна.


Энэхүү бирж нь 1990 онд Шанхай, Шэньжэний биржийг нээсний дараах Хятадын гурав дахь хөрөнгийн бирж болсон байна.

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

S&P 500 /<sup>^</sup>GSPC/


**4,697.96** +60.65 (+1.32%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Nikkei 225 /<sup>^</sup>N225/


**29,776.80** +190.63 (+0.67%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

FTSE 100 /<sup>^</sup>FTSE/


**7,110.00** +65.92 (+0.94%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

NASDAQ Composite (^IXIC)

**15,782.83** +291.18 (+1.88%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia